



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 05 өдөр

Дугаар A/60

Сүхбаатар сум

Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх  
ажлыг эрчимжүүлэх тухай

“Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.“м”, “н”, 39.1, 39.2, “Ойн тухай хууль”-ийн 17 дугаар зүйлийн 17.2.6, 17.2.18, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, 37 дугаар зүйлийн 37.1, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх заалт, Монгол Улсын шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан 2019 оны “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг эрчимжүүлэх тухай” 12/A/51 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт ой, хээрийн түймэр гарах байгалийн нөхцөл бүрдсэн хуурайшилт бүхий цаг хугацаа буюу 03 дугаар сарын 06-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд ойд мод бэлтгэх, ойн дагалт баялгийг ашиглах, ойд аялал зугаалгаар явах, ан хийх, бугын эвэр түүх болон бусад үйл ажиллагаа явуулахыг аймгийн хэмжээнд түр зогсоосугай.

2. Түймрийн аюултай үе эхэлж байгаатай холбогдуулан ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулан хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, малчин айл өрх, ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, аж ахуй нэгж болон бусад байгууллагуудтай хамтран морьт болон гэрээт эргүүл, харуул томилон гэрээ байгуулан ажиллахыг сумдын Засаг дарга, сумын болон сум дундын Ойн ангийн дарга нарт даалгасугай.

3. Ойн санг гэрээгээр эзэмшигч, иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагуудын ойн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэмцэх ажлын хүрээнд хийгдэж буй ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, ажлын явц үр дүнгийн талаар аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /З.Түвшинтөгс/, Мэргэжлийн хяналтын газрын дарга /Ж.Отгонхүү/ нарт тус тус үүрэг болгосугай.

4. Онцгой байдлын газрын бие бүрэлдэхүүн машин техникийн бэлтгэл, бэлэн байдлыг хангаж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, түймрийн мэдээллийг шуурхай солилцох, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх

My Doc Zahiramj

ажлыг тогтмол зохион байгуулахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа /Г.Баатар/- д даалгасугай.

5.Онцгой байдлын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт дээрх хугацаанд байнгын жижүүрийг тодорхой удирдамжтай ажиллуулахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга/ Г.Баатар/, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /З.Түвшинтөгс/, нарт тус тус даалгасугай.

6.Ой, хээрийн түймэр гарсан тохиолдолд шалтгаан нөхцөлийг хуулийн хугацаанд шалган тогтоож, эзэн холбогдогчдод хариуцлага тооцож, авсан арга хэмжээний талаар олон нийтэд мэдээллэж байхыг аймгийн Цагдаагийн газрын дарга /А.Энхбат/, Мэргэжлийн хяналтын газрын дарга /Ж.Отгонхүү/ нарт үүрэг болгосугай.

7.Хилийн бүс, хил орчмын нутаг дэвсгэр, хил дамнан ой, хээрийн түймэр гарсан тохиолдолд түймрийн тэрхалтыг таслан зогсоох зорилгоор хоёр улсын томилгоот албан хаагчдыг хялбаршуулсан журмаар хил нэвтрүүлэх ажлыг Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулж ажиллахыг Хилийн 0243 дугаар ангийн захирагч /Б.Гантөмөр/-д даалгасугай.

8.Захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг сумдын Засаг дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Хилийн цэргийн 0243 дугаар анги, Цагдаагийн газар, сум дундын Ойн ангиудын удирдлагуудад үүрэг болгосугай.

9. Түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, унтраасан тухай ажлын үр дүнг аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулахыг аймгийн Засаг даргын орлогч, ой, хээрийг түймрээс хамгаалах үйл ажиллагааг зохицуулах зөвлөлийн дарга /Ж.Сайнцог/- д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ